

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 17-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 17-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 05 дугаар сарын 17-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4-7
<hr/>	
1.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/	4-5
2.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	5-7

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 17-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
05 дугаар сарын 17-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 16 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 56.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 17 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: С.Батболд;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Э.Бат-Амгалан, Ц.Сэргэлэн, Д.Цогтбаатар.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, дэд дарга Б.Баасандорж, мөн газрын Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Хуулийн багийн ахлах зөвлөх Ч.Ариунхур, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Дондогмаа, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Ү.Амарбат, Монгол Улсын Их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор Д.Бумдарь нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, Н.Мөнхзэсэм, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Энх-Амгалан: Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 15 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, дэд дарга Б.Баасандорж, мөн газрын Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Хуулийн багийн ахлах зөвлөх Ч.Ариунхур, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Дондогмаа, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Ү.Амарбат, Монгол Улсын Их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор Д.Бумдарь нар оролцов.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 17-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, Н.Мөнхзэсэм, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Энх-Амгалан: 1.Төслийн 1 дүгээр зүйлийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3. Төслийн 3 дугаар зүйлийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Эрдэнэбат Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 10 минут үргэлжилж, 16 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 68.8 хувийн ирцтэйгээр 15 цаг 27 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХ-АМГАЛАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 17-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 05 дугаар сарын 17-ны өдөр,
Лхагва гараг Төрийн ордон
“Их засаг” танхим
15 цаг 17 минут.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023
ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
05 ДУГААР САРЫН 17-НЫ ӨДӨР
ЛХАГВА ГАРАГ/-ИЙН
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ**

Б.Энх-Амгалан: Ажлын хэсгийг оруулъя.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдааны ирц бүрдсэн тул 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46.2-т заасан Байнгын хорооны ирцийг танилцуулъя.

Б.Энх-Амгалан ирсэн. Н.Алтанхуяг чөлөөтэй. Г.Амартүвшин чөлөөтэй. П.Анужин ирсэн. Э.Бат-Амгалан гишүүнийг уриарай. Б.Баттөмөр гишүүн ирсэн. Х.Баделхан гишүүн ирсэн. С.Батболд гишүүн орон нутагт томилолттой. Б.Бат-Эрдэнэ гишүүн ирсэн. Д.Ганбат гишүүнийг хуралдаа оролцохыг урьж байна. Б.Дэлгэрсайхан гишүүн ирсэн. Н.Наранбаатар гишүүн ирсэн. Ц.Сэргэлэн гишүүн чөлөөтэй. Д.Цогтбаатар гишүүн чөлөөтэй. Н.Энхболд гишүүн ирсэн. Ж.Эрдэнэбат гишүүн ирсэн. Амартүвшин гишүүн ирж байна. Амартүвшин гишүүний ирцэд бүртгээрэй.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл. Монгол Улсын Засгийн газар 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр өргөн мэдүүлсэн, 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгэх.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл. Монгол Улсын Засгийн газар 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг явуулна.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Дашизэвэгийн Амарбаясгалан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Барсүрэнгийн Баасандорж Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга, Үүрцайхын Амарбат Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх, Чулуунбаатарын Дондогмаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга, Ганбат Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга, Чулуунбаатарын Дондогмаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль эрх зүйн газрын дарга, Чойжилсүрэнгийн Ариунхур ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газрын хуулийн багийн ахлах зөвлөх, Дагва-Очирын Бумдарь МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Улс төр судлалын тэнхимийн багш профессор. Хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн гишүүдийг танилцууллаа.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 49.1-д зааснаар Байнгын хороод Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13 дугаар зүйлд

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 17-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

заасны дагуу Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэж, санал дүгнэлтээ гаргана гэж. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 13.2-т бусад Байнгын хороо уг төслийн талаар тус тусын санал, дүгнэлтээ Байнгын хорооны хурал дээр хэлэлцэж, Төрийн байгуулалтын байнгын хороонд өгнө гэж заасан байна.

Хууль санаачлагчаас асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү. Алга байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Зарчмын зөрөөтэй санал гишүүдээс ирээгүй. Зарчмын зөрөөтэй санал байхгүй.

Ганбат гишүүн ирж байна, бүртгэлд оруулаарай.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн 2 дахь хэлэлцүүлэгт оруулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Түр хүлээж байгаарай, санал хураалтыг цуцалъя. Ганбат гишүүн ирцэд орж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг 2 дахь хэлэлцүүлэгт оруулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүд ээ.

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 72.7 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

15.22 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд

шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу зүйл бүрээр хэлэлцье.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөх ч дөхөж шилжих журмын тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

1 дүгээр зүйлтэй холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөх шилжих журмын тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, санал хураалт 72,7 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Асуултыг тасаллаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдийн бичгээр гаргасан санал хураалт алга байна. Зарчмын зөрөөтэй санал алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйл зүйлийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

11 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 72.7 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Гишүүд асуулт асууж дууслаа.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 17-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Хуулийн төсөлтэй холбогдуулан бичгээр ирүүлсэн санал байхгүй, зарчмын нүүртэй санал байхгүй.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Нийт 10 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 80 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөх шилжих журмын тухай хуулийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөх шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд Монгол Улсын Их Хурлын гишүүн Баделхан гишүүн танилцуулъя. Ж.Эрдэнэбат гишүүн байдаг, тийм ээ. Ж.Эрдэнэбат гишүүн танилцуулъя.

Санал, дүгнэлттэй холбоотойгоор Нямаагийн Энхболд гишүүн үг хэлье гэж байна. Энхболд гишүүний микрофоныг өгье.

Н.Энхболд: Баярлалаа. Байнгын хорооны дарга аа. Манай Байнгын хороогоор 2 дахь хэлэлцүүлэг явчихлаа. Үүний өмнө намын бүлгүүд, намын удирдлагууд, Их Хуралд суудалтай намуудын удирдах байгууллагуудын одоо тодорхой шийдвэрүүд гарсан. Үүний дагуу Их Хурал дээр мөн одоо холбогдох хүрээнд зөвшилцөл ойлголцол явагдсан. Ингээд сая Улсын Их Хурлын гишүүд орон

нутагт тойргоороо ажиллаж ирсэн. Ажилласан үеэр иргэд сонгогчдоос гарсан саналууд, бусад намууд, Улсын Их Хуралд суудалтай намуудын удирдлага, удирдах байгууллагуудынх нь түвшинд ойлголцсоны үндсэн дээр ерөнхийдөө 152 гишүүнийг бол арай олон байна гэдгээр нь энэ тоог нь доошлуулж, ярилцъя, 2 дугаар хэлэлцүүлгээр гэдэг агуулгаар. Тэгээд холимог тогтолцоогоо дэмжсэн 76 тойргоо хэвээр нь үлдээх ийм агуулгын хүрээнд 2 дугаар хэлэлцүүлгүүд явж байгаа гэж ойлгож саналаа өгсөн гэдгээ протоколд үлдээчихье. Баярлалаа.

Б.Энх-Амгалан: Баярлалаа. Нямаагийн Энхболд гишүүний хэлсэн саналыг протоколд тэмдэглэж үлдээгээрэй.

15.27 цаг

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал ингээд үүгээр өндөрлөж байна.

Гишүүд болон ажлын хэсэгт баярлалаа.

Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

Хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ